

## ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**МОНГОЛД ХРИСТОСЫН ШАШНЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ  
ГЭСЭН ОРОЛДЛОГО**

(Архивын материалаас)

**Л. Лувсанчүлтэм**

Капитализмын хөгжлийн үед баруун Европын том хөрөнгөтөн орнууд Ази, Африкийн бага буурай улс орны нутаг дэвсгэрийг хүчээр түрэмгийлэн булаан эзлээд тэдгээр орны эдийн засаг, улс төрийн тусгаар тогтнолыг алдагдуулж, өөрсдийн эзэмшлийн нутаг болгож байсан үест колони ба хараат орнууд үүсчээ.

ХҮ-ХҮІ зуунд Испани, Португали улсууд нэгэнт колони гүрэн болсон ба ХҮП-ХҮШ зуунд Нидерланд, Их Британи зэрэг улсууд колонийн бодлогыг идэвхтэй явуулах замд орсон ажээ. XX зууны эхэн гэхэд Их Британи, Франц, Америк, Итали, Нидерланд мэтийн томоохон колоничлогч улсууд бүх дэлхийн бага буурай орны нутгийг өөр хоорондоо нэгэнт хуваан авсан байв. Гэвч одоо дэлхийн колонийн систем нэгэнт унасан учир империалистууд шинэ колончлолын бодлого явуулахыг оролдож байгаа боловч тэр нь биелэгдэх ямар ч тавилангүй байжээ.

Колоничлогчдын ердийн заншлаас товчхон хэлбэл: Тэд нар Ази буюу Африкийн аль нэгэн улс оронд эхлэн орж ирэхдээ тэр орны зах нутгийн жижиг тосгонд суурьшиж, уул нутгийн хүмүүстэй харилцахдаа даруу томоотой авир зан үзүүлэн, эвтэй найртай байж байгаад ард түмний байдал, цэргийн чадал, байгалийн баялгийг сэмхэн мэдэж аваад, тэр орны ноёдыг хахуулдах, хуурах арга мэх хэрэглэн, заримдаа зэвсэг хэрэглэх зэргээр алгуур хугацаанд алхам алхмаар давшиж өөрсдийн суурьшсан нутаг дэвсгэрийг өргөтгөн эрхшээлдээ оруулдаг байв.

Колоничлогчид нь байн байсаар зөвхөн өөрсдийн ашиг олзыг хамгаалах төдийгүй харин харьяат засгийн газрын нэрээр ажиллах болж, улсын зэвсэгт хүчнийг хэрэглэх эрхтэй болдог байна. Тэгээд ямар нэгэн өө сэв сэдэв олж, түүгээр шалтгаалан гэнэт цэрэг зэвсгийн хүч хэрэглэн, тэр улсыг сөнөөж, түүний ард иргэдийг зовоон мөхөөгөөд, түүнээс үлдсэнийг нь боол шивэгчнээс доогуур бүр ажлын мал мэт болгон зовоодог байжээ.

Бага буурай хоцрогдсон орны хүн ардын зан ааш номхон, соёл боловсрол мөхөс, зэр зэвсэг бүдүүлэг тул байлдан дагуулахад төдий л бэрх бус байдаг учир тийнхүү ховдог шунахай, хэрцгий балмад колоничлогчид олноор үймэлдэн очиж, тэр «шинэ газрын» хүмүүсийг алж талан сүйтгэж, хамаг баялгийг нь булаан дээрэмддэг түүхтэй

билээ. Колонит гүрнүүд (метрополиуд) тус тусын нөлөөний хүрээг бэхжүүлэн өргөтгөх зорилтыг тавихдаа Ийсус Христосын шашныг<sup>1</sup> өргөн ашиглажээ. Энэ үеэр Европт «Христосын шашингүй хүмүүсийг номд оруулах шашин номлогчдын (Миссионеруудын) нийгэмлэг» гэдэг байгууллага бий болсон байв. Иймд Англи, Франц, Америк, Герман, Итали зэрэг капиталист гүрний засгийн газрууд дээрх «нийгэмлэгт» багтсан өөр өөрийн харьяаны шашин номлогчдын зүйл бүрийн тэтгэмж, тусламж, эрх хөнгөлөлт олгоод, тусгай даалгавар өгч, олон улс оронд тухайлахад Энэтхэг, Хятад Малайз, Филиппин болон Ар, Өвөр Монголд илгээж байв. Христосын ёсны католик шашин номлогч тэдгээр Миссионерүүд хүрч очсон газар бүртээ өөрийн бурхан шашны ач авралыг сурталчлан, хүн ардад сүжиг бишрэл төрүүлж, тэдний санаа сэтгэлийг христосын ном руу урвуулан хандуулахын тул онц идэвхтэй ажиллаж байв. Ялангуяа Хятад мэтийн орны ард түмний дунд өргөн дэлгэр ажил зохион явуулж, тэдний итгэл найдварыг олж байжээ.

Хятад ба Өвөр Монголын нутагт: Ийсус Христосын шажин сургууль, Христосын ариун сургаалын номыг тараах хэвлэл, Өнчин хүүхдийг асарч хүмүүжүүлэх байр, Өвчтөнийг үнэ төлбөргүй эмчлэн сувилах эмнэлэг гэх мэтийг байгуулж ажиллуулсан байна. Түүнчлэн Өвөр Монголын Цахар адуучин хошууны Хатан сүмд «Ийсусын сургаалын орон»<sup>2</sup> гэдэг хэвлэлийн газар байгуулаад «Ийсусыг итгэж авралыг олсон нь», «Ийсусын мөргөлийн ном» гэх зэрэг олон зүйлийн номыг 1924—1930 оны хооронд монгол хэлээр олон хувь хэвлэн тарааж байжээ.

Ийнхүү христос шашныг Монгол газар, тухайлбал Ар Монголд ч дэлгэрүүлэх гэж оролдож байсан тухай ховор материал БНМАУ-ын түүхийн төв архивын манж хэлний хөмрөгт хадгалагдаж байна. Уул материалыг судалж үзвэл, 1855 онд хятад-англи, хятад-францын хооронд гэрээ байгуулагдаж, Манж гүрний харьяа нутаг орны хүн ардад христосын ном, сургаал номлох явдал албан ёсоор зөвшөөрөгдсөн байна. Иймийн тул Ар Монгол Их хүрээ, Улиастай, Ховд хотын амбан захирагч нараас «христосын лам нар өөрийн шашны сургаал номлохоор Монгол газар ирэхэд тогтсон гэрээ ёсоор тэд нарыг хамгаалан тусалж байсугай»<sup>3</sup> гэж Ар Монголын бүх хошуунд зарлан тушаасан байна. Тэгээд төдий л удалгүй Бээжингийн Монгол-Төвдийн хэрэг эрхэлсэн Яамны хятад түшмэдээс олгосон тамгатай үнэмлэх бичиг бүхий христос нийгэмлэгийн төдөөлөгчид—миссионерууд Их Хүрээнд удаа дараа хүрч ирээд монголчуудад Евангели судар номлож эхэлсэн байна.

1878 оны зун Их Хүрээнд амбан захирагчаас Халхын Түшээт хан, Сэцэн хан хоёр аймагт зарласан бичигт өгүүлсэн нь: «Францын хар лам...гурван хүн монгол газар христосын сургаал номлох тул уг хэрэг нь үнэн санаагаар тусал»<sup>4</sup> гэжээ.

Мөн оны намар Цахарын амбанаас Хүрээний амбанд ирүүлсэн албан захидалд бичсэн нь: «Америкийн хар лам нар Халх Монголд очиж ном номлох гэсэн тул үнэмлэх олгож явуулав»<sup>5</sup> гэжээ.

1. Энэ шашин I-II зуунд Ромын эзэнт улсын харьяа олон оронд дэлгэрээд ҮП зууны үед дорно дахинд нэвтэрч эхэлжээ.

2. Монгол номын гарчиг. 0134, 0135

3. УТТА Ф № 1, ХН 321

4. УТТА Ф № 1, ХН 267. Жич тайлбар: уг бичигт 3 хар ламын нэрийг Ван Цзунган, Мэн Шуйчин, Ши Тяньчи хэмээн хятад аялгуугаар бичжээ.

5. Мөн Ф № 2, ХН 78,

1888 оны өвөл Улиастайн манж жанжнаас «Герман, Англи, Италийн хар лам нар Монголын олон хошуунд христосын шашин номлохоор явсан тул орон нутгийн түшмэл, ардууд талархан үзвэл зохино»<sup>6</sup> гэж тушаажээ.

1894 онд Бээжингээс үнэмлэхтэй ирсэн Норвеги улсын хар лам (нангиад аялгуугаар Шин Хуазун гэгч хүн) Халхын Их Хүрээнд 4 жил сууж, монголчуудад христосын ном номлон байсан бөгөөд тэдгээр 1898 онд тэр цагийн Дархан бэйсийн хошууны ноён Пунцагцэрэнд ном номлох танхим болон өвчтөн сувилах байр байгуулахыг хүсч өргөдөл бичсэн нь: «Номын ёс сонсохыг хүссэн монгол хүн маш олон байна. Хөлслөн суусан байшин бага, олон хүн шахцалдан байдаг тул өөр томхон байшин бариулахад хэрэглэх гуалин 6000 ширхэгийг олгоно уу»<sup>7</sup> гээд уг модыг бэлтгэн авах зөвшөөрөл олж авсан байна.

1905 онд Их Хүрээнд ирсэн Америкийн нэг хар лам, амбан яамны монгол түшмэл Лувсанцэрэн гэгчтэй уулзаж ярьсан нь: «Миний нэр Олаф Севарон Несгурд, ноднин танай энд ирсэн. Монгол хүнд бурхны ном сургах сургууль байгуулах санаатай боловч завдаагүй байна. Иймд миний энэ буюаны хэрэгт туслахыг хүсье»<sup>8</sup> гэсэн гэж мөн яамны өдрийн тэмдэглэл дансанд бичжээ. Эдгээрийн дараа бас Хятадын хөрөнгөтний засгийн үед гоминданы ноёдууд Ар Монголыг түрэмгийлэн эзлэхээр санаархаж, ил, далд элдэв хортой ажиллагаа хийхдээ тухайн үед Өвөр Монгол ба Хятадад байсан баруун орны миссионеруудыг өөрийн түрэмгий бодлогод ашиглахын тул тэд нарыг туслан дэмжиж, Халх Монгол руу шургуулан оруулж байв. Жишээ нь: 1921—1923 онд Хятадын гоминданы захиргаанаас олгосон үнэмлэх бичиг бүхий христос шашны хувраг хэдэн англи эмэгтэй Улаанбаатар хотноо хүрэлцэн иржээ. Тэд ирснийхээ дараа Евангели судраас иш татаж зохиосон элзэв зураг хөрөг бүхий монголоор бичсэн ном, товхимолыг олон хувиар тарааж эхэлжээ. Мөн өвчин эмгэгтэй хүмүүсийг үнэ төлбөргүй эмчлэн сувилна гэж өргөн зарласан тухайн үедээ бас нэгэн мунхаг хүмүүсийн итгэлийг түр зуур боловч олжээ. Иймээс тэдгээр эмэгтэй санваартан нарт нэг хэсэгтээ өвчнөө эмчлүүлэх, биеэ үзүүлэхээр зарим монгол хүмүүс очдог байжээ. Бас хүүхэд багачууд өнөөх Евангели судараас орчуулан хэвлэсэн гоё сайхан зурагтай ном дэвтрийг их сонирхож, түүнийг олж авахын дулд тэдгээр англи эмэгтэйчүүд рүү гүйдэг байв.

Тэд нар цугларагсдад номлохдоо: «Хэн хүн христосыг бишрэн шүтэж, түүний зарлигийн ёсоор үйлдвээс зовлонгоос аврагдаж, тэнгэрийн жаргалант орноо төрнө, та бүхний ганц эзэн эцэг бол христос бурхан мөн» гэх мэтээр номлож байжээ.

Монгол хэлээр ном номлогч тэдгээр эмэгтэйчүүдийн царай зүс үзэсгэлэн гуа, зан авир эелдэг зөөлөн, үг яриа уран цэцэн тул нялх оюут хүмүүсийг амархан бишрүүлэх чадал төгс мэт байв. Ялангуяа монгол хэл сайн мэддэг тул цугларсан хүмүүст номныхоо утгыг хялбар ойлгуулан чадах сайн нөхцөлтэй байжээ. Дээрх байдлаас үзвэл эдгээр эмэгтэй санваартнуудыг урьдаас зориуд бэлтгэж ямар нэгэн зорилгоор Монголд явуулсан болох нь тодорхой байна.

Ингэж байтал 1923 онд БНМАУ-ын судар бичгийн хүрээлэнгийн гишүүн эрдэмтэн Дандаа энэ явдлыг үзээд ийм хэрэг урьд Өвөр

6. УТТА Ф № 1. ХН 429.

7. УТТА Ф № 1. ХН 213.

8. УТТА Ф № 1. ХН 218.

Монголд гарсан бөгөөд дараагаар нь жигтэй муу явдал үүсч байсан тул манай энд үүнийг шууд хоригловол зохино гэж учрыг тайлбарлан засгийн газар мэдүүлсэнд тэр даруй тус улсын цагдан сэргийлэхээс тэдний тарааж байсан ном дэвтрийг хураан аваад Монголоос буцаан гаргасан билээ.

Ингэж XIX зууны сүүлчээс эхлэн Ардын хувьсгалын эхний жилүүд хүртэл Европ, Америкийн хар лам нар манай оронд удаа дараа ирцгээж, христосын шашныг сурталчилж улмаар өөрсдийн орны улс төр—үзэл суртлын нөлөөг Монголд оруулах гэж оролдож байсан боловч манай Ардын засгийн газраас авсан арга хэмжээний үрээр христосынхны дээрх ажил амжилт олоогүй устаж арилсан түүхтэй билээ.

## ПОЛЫТКИ РАСПРОСТРАНЕНИЯ ХРИСТИАНСКОЙ РЕЛИГИИ В МОНГОЛИИ

(Резюме)

Автор на основе анализа архивных материалов, имеющихся в Государственном Центральном архиве МНР на маньчжурском языке, рассказывает о неоднократных попытках распространить в Монголии христианскую религию с середины XIX в вплоть до второй четверти нынешнего столетия, которые упорно предпринимались западными христианскими миссионерами, в частности, по заключенным Китаем с Англией и Францией в 1855 году соглашениями официально разрешалось западным христианским миссионерам проповедовать свою религию на территории Цинской империи, включая «Внешнюю» Монголию.

Вероятно, по этим и другим соглашениям, как отмечает автор, в 1878, 1888 гг. в города Ургу и Улясутай, а также в Цэцэнханский и Тушэтуханский аймаки Халхи приезжали монахи из Франции, Англии, США, Германии и Италии для проповеди христианской религии. В 1894 году один норвежский монах (по китайскому произношению Шин Хуазун), имевший удостоверение от цинского Китая, проживал в Урге в течении 4-х лет. За время своего пребывания в Халхе он организовал школу для проповеди христианской религии среди монгольского населения. Имеются также документы, свидетельствующие о том, что он просил строительные материалы для больницы, где могли бы лечиться монголы.

В 1905 году в Ургу также приезжал один монах из США с целью организации христианской религиозной школы.

Даже после победы Народной революции в Монголии буржуазно помещичий режим Китая в целях подрыва Народного Правительства Монголии в 1921—1923 гг. тайно послал в нашу страну группу английских привлекательных монахиней из Внутренней Монголии. Они, прекрасно владевшие монгольским языком, проповедывали христианскую религию среди населения, особенно среди женщин путем распространения Евангельских книг и брошюр, напечатанных на монгольском языке, насаждения им различных суеверий, лечения больных и т. д.

Подобные попытки группы английских монахиней распространить в Монголии христианскую религию были пресечены Народной властью и эти английские монахини выдворились из Монголии.